

**ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН БИЕЛЭЛТЭД ХИЙСЭН  
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАНИЛЦУУЛГА  
/2019 оны эхний хагас жил/**

2019 оны 06 дугаар сарын 27

**Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго.**

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлаар батлагдсан хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн явц, үр дүнд 2019 оны эхний хагас жилийн байдлаар хяналт-шинжилгээ хийж, зорилтыг хүрэх түвшинтэй нь харьцуулан, хэрэгжилтийн түвшинг тогтоох, үр дүнг үнэлэх, дүгнэлт, зөвлөмж гаргах, яамны удирдлагыг бодит мэдээллээр хангах, цаашид төлөвлөсөн зорилтыг бүрэн биелүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд оршино.

**Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээний арга зүй.**

Монгол Улсын хууль, Улсын Их Хурал болон УИХ-ын Байнгын хорооны тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж, хуралдааны тэмдэглэл, Засгийн газрын тогтоол, хуралдааны тэмдэглэл, Ерөнхий сайдын захирамж, албан даалгавраар Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд гарсан шийдвэр, зүйл, заалтыг хяналтад авч, яамны нэгжүүдийн 2019 оны эхний хагас жилийн байдлаар ирүүлсэн биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийв.

Хяналт-шинжилгээ, үнэлгээг хийхдээ Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”, Уул уурхайн хүнд үйлдвэрийн сайдын 2017 оны А/122 дугаар тушаалаар батлагдсан журмыг тус тус удирдлага болгов.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгдсэн цахим хуудсанд байршуулсан шийдвэр, зүйл, заалтыг 2019 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн байдлаар тасалбар болгон Засгийн газрын 2017 оны 89-р тогтоолоор батлагдсан журмын 6-р хавсралтын дагуу салбар тус бүрээр Геологи, эрдэс баялгийн, Газрын тос, газрын тосны бүтээгдэхүүн түүний нөөцийн, Уул уурхайн, Хүнд үйлдвэрийн, Нийтлэг асуудал гэсэн таван ангиллаар хэрэгжилтийг гаргуулав.

**Гурав. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн.**

2019 оны эхний хагас жилийн үнэлгээг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний [www.unelgee.gov.mn](http://www.unelgee.gov.mn) цахим системд байршуулсан нийт 90 шийдвэрийн 119 зүйл, заалтыг дээр дурдсан агуулгаар ангилж хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн ба хэрэгжилтийг **74.4** хувийн биелэлттэй дүгнэв.

Үүнд Геологи, эрдэс баялгийн бодлогын хүрээнд 9 шийдвэрийн 10 заалтын хэрэгжилт 70%, Газрын тос, газрын тосны бүтээгдэхүүн болон түүний нөөцийн талаарх бодлогын 12 шийдвэрийн 17 заалтын хэрэгжилт 70,5%, Уул уурхайн бодлогын 41 шийдвэрийн 53 заалтын хэрэгжилт 79,1%, Хүнд үйлдвэрийн бодлогын 15 шийдвэрийн 24 заалтын хэрэгжилт 65,6%, Нийтлэг асуудлын 13 шийдвэрийн 15 заалтын хэрэгжилт 81,4%-ийн тус тус биелэлттэй байна.

**УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМНЫ ЭРХ ЗҮЙН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ НЭГТГЭЛ**

Хүснэгт-1

Салбар, чиглэлийн нэр	Хяналтанд авсан тоо		Хэрэгжилтийн явц /хувиар/				Үнэлээгүй	Үнэлгээ /%/
	Шийдвэр	Зүйл, заалт	100%	70%	30%	0%		
<b>НЭГ. ГЕОЛОГИ, ЭРДЭС БАЯЛГИЙН БОДЛОГО</b>								
Монгол Улсын хууль	.-	.-	.-	.-	.-	.-	.-	.-
УИХ-ын тогтоол	.-	.-	.-	.-	.-	.-	.-	.-
ҮАБЗ-ийн зөвлөмж, тэмдэглэл	.-	.-	.-	.-	.-	.-	.-	.-
Засгийн газрын тогтоол	5	6	3	1	2	.-	.-	71.6
Ерөнхий сайдын захирамж	.-	.-	.-	.-	.-	.-	.-	.-
ЗГ-ын хуралдааны тэмдэглэл	4	4	1	1	1	.-	1	66.6
<b>ГЭББ-ын дүн</b>	<b>9</b>	<b>10</b>	<b>4</b>	<b>2</b>	<b>3</b>	<b>.-</b>	<b>1</b>	<b>70.0</b>
<b>ХОЁР. ГАЗРЫН ТОС, ГАЗРЫН ТОСНЫ БҮТЭЭГДЭХҮҮН БОЛОН ТҮҮНИЙ НӨӨЦИЙН ТАЛААРХ БОДЛОГО</b>								
Монгол Улсын хууль	1	3	2	1	.-	.-	.-	90.0
УИХ-ын тогтоол	1	1	1	.-	.-	.-	.-	100.0
ҮАБЗ-ийн зөвлөмж, тэмдэглэл	2	2	1	.-	1	.-	.-	65.0
Засгийн газрын тогтоол	2	3	1	.-	2	.-	.-	53.3
Ерөнхий сайдын захирамж	1	1	.-	.-	1	.-	.-	30.0
ЗГ-ын хуралдааны тэмдэглэл	5	7	2	4	1	.-	.-	72.8
<b>ГТГТБТНТБ-ын дүн</b>	<b>12</b>	<b>17</b>	<b>7</b>	<b>5</b>	<b>5</b>	<b>.-</b>	<b>.-</b>	<b>70.5</b>
<b>ГУРАВ. УУЛ УУРХАЙН БОДЛОГО</b>								
Монгол Улсын хууль	2	2	1	1	.-	.-	.-	85.0
УИХ-ын тогтоол	1	2	.-	2	.-	.-	.-	70.0
УИХ-ын Байнгын хорооны тогтоол	3	4	1	3	.-	.-	.-	77.5
ҮАБЗ-ийн зөвлөмж, тэмдэглэл	2	3	3	.-	.-	.-	.-	100.0
Засгийн газрын тогтоол	16	19	8	5	4	.-	2	74.7
Ерөнхий сайдын захирамж	3	3	.-	.-	1	.-	2	30.0
ЗГ-ын хуралдааны тэмдэглэл	14	20	10	4	2	.-	4	83.7
<b>УУБ-ын дүн</b>	<b>41</b>	<b>53</b>	<b>23</b>	<b>15</b>	<b>7</b>	<b>.-</b>	<b>8</b>	<b>79.1</b>
<b>ДӨРӨВ. ХҮНД ҮЙЛДВЭРИЙН БОДЛОГО</b>								
Монгол Улсын хууль	2	2	1	1	.-	.-	.-	85.0
УИХ-ын тогтоол	1	2	1	.-	1	.-	.-	65.0
ҮАБЗ-ийн зөвлөмж, тэмдэглэл	.-	.-	.-	.-	.-	.-	.-	.-
Засгийн газрын тогтоол	4	10	2	3	4	.-	1	58.8
Ерөнхий сайдын захирамж	2	2	.-	1	1	.-	.-	50.0
ЗГ-ын хуралдааны тэмдэглэл	6	8	2	5	1	.-	.-	72.5
<b>ХҮБ-ын дүн</b>	<b>15</b>	<b>24</b>	<b>6</b>	<b>10</b>	<b>7</b>	<b>.-</b>	<b>1</b>	<b>65.6</b>
<b>ТАВ. НИЙТЛЭГ АСУУДАЛ</b>								
Монгол Улсын хууль	.-	.-	.-	.-	.-	.-	.-	.-
УИХ-ын тогтоол	1	1	1	.-	.-	.-	.-	100.0
Ерөнхийлөгчийн зарлиг	1	2	2	.-	.-	.-	.-	100.0
ҮАБЗ-ийн зөвлөмж, тэмдэглэл	.-	.-	.-	.-	.-	.-	.-	.-
Засгийн газрын тогтоол	8	8	4	2	2	.-	.-	75.0
Ерөнхий сайдын захирамж	1	1	.-	.-	.-	.-	1	.-

ЗГ-ын хуралдааны тэмдэглэл	2	3	1	2				80.0
Нийтлэг асуудлын дүн	13	15	8	4	2	.-	1	81.4
<b>Эрх зүйн баримт бичгийн дүн</b>	<b>90</b>	<b>119</b>	<b>48</b>	<b>36</b>	<b>24</b>	<b>.-</b>	<b>11.0</b>	<b>74.4</b>

Нийт 90 шийдвэрийн 119 зүйл, заалтын 11 нь үнэлэх боломжгүй буюу үнэлгээ өгөөгүй бөгөөд хэрэгжилт гаргаж дүгнэсэн 108 заалтын 48 заалт буюу 44,4% бүрэн биелсэн, 36 заалт буюу 33,3% хэрэгжилтийн шатанд 70 хувийн биелэлттэй, 24 заалт буюу 22,2% нь хэрэгжилт удаашралтай байна.

**ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ҮНЭЛГЭЭ**  
/Хууль тогтоомжийн төрлөөр/

Хүснэгт-2

	Бүгд	Монгол Улсын хууль	Улсын Их Хурлын тогтоол	УИХ-ын Байнгын хорооны тогтоол	Ерөнхийлөгчийн зарлиг	ҮАБЗ-ийн зөвлөмж, тэмдэглэл	Засгийн газрын тогтоол	Ерөнхий сайдын захирамж	Засгийн газрын хуралдааны тэмдэглэл	
Хяналтанд авагдсан шийдвэрийн тоо	90	5	4	3	1	4	35	7	31	
Заалтын тоо	119	7	6	4	2	5	46	7	42	
Үүнээс	Биелсэн 100%	48	4	3	1	2	4	18	.-	16
	Хэрэгжих шатанд 70.0%	36	3	2	3	.-	.-	11	1	16
	Хэрэгжилт хангалтгүй 30.0%	24	.-	1	.-	.-	1	14	3	5
	Хэрэгжээгүй 0%	.-	.-	.-	.-	.-	.-	.-	.-	.-
	Дүгнэгдээгүй	11	.-	.-	.-	.-	.-	3	3	5
<b>Үнэлгээ</b>	<b>74.4</b>	<b>87.1</b>	<b>78.3</b>	<b>77.5</b>	<b>100.0</b>	<b>86.0</b>	<b>69.5</b>	<b>40.0</b>	<b>77.5</b>	

Эрх зүйн актын хэрэгжилтийг төрлөөр нь авч үзвэл:

- Монгол Улсын 5 хуулийн 7 заалтаас бүрэн хэрэгжсэн 4, хэрэгжих шатанд 3, хэрэгжилтийн дундаж 87,1%-тай;
- Улсын Их Хурлын 4 тогтоолын 6 заалтаас бүрэн хэрэгжсэн 3, хэрэгжих шатанд 2, хэрэгжилт удаашралтай 1, хэрэгжилтийн дундаж 78,3%-тай;
- УИХ-ын Байнгын хорооны 3 тогтоолын 4 заалтаас бүрэн хэрэгжсэн 1, хэрэгжих шатанд 3, хэрэгжилтийн дундаж 77,5%-тай;
- Ерөнхийлөгчийн 1 зарлигийн 2 заалтаас бүрэн хэрэгжсэн 2, хэрэгжилтийн дундаж 100,0%-тай;
- Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 4 шийдвэрийн 5 заалтаас бүрэн хэрэгжсэн 4, хэрэгжилт удаашралтай 1, хэрэгжилтийн дундаж 86,0%-тай;
- Засгийн газрын 35 тогтоолын 46 заалтаас бүрэн хэрэгжсэн 18, хэрэгжих шатанд 11, хэрэгжилт удаашралтай 14, хэрэгжилтийн дундаж 69,5%-тай;
- Ерөнхий сайдын 7 захирамжийн 7 заалтаас хэрэгжих шатанд 1, хэрэгжилт удаашралтай 3, хэрэгжилтийн дундаж 40,0%-тай;

- Засгийн газрын хуралдааны 31 тэмдэглэлийн 42 заалтаас бүрэн хэрэгжсэн 16, хэрэгжих шатанд 16, хэрэгжилт удаашралтай 5, хэрэгжилтийн дундаж 77,5%-тай байна.

### **Дөрөв. Дүгнэлт.**

1. Яамны холбогдох газруудаас хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг хэрэгжүүлэх талаар үр дүнтэй ажлууд хийж байгаа боловч биелэлтийг тогтоосон хугацаанд гаргаж ирүүлэх, ажлын гол үр дүнг товч тодорхой, баримт нотолгоонд суурилсан байдлаар тайлагнах шаардлагатай байна.
2. Бусад байгууллагатай хамтран хэрэгжүүлэх шийдвэрийн биелэлт хангалтгүй, тухайн асуудлаар толгойлон эсвэл хамтран хэрэгжүүлэгчээс санал авч, хамтарч биелэлтийг тайлагнадаггүй байдал давтагдаж байна.
3. Яамны эрхлэх асуудалд хамааралгүй, хэрэгжих хугацаа болоогүй, үндсэн хэрэгжүүлэгч яамнаас санал ирээгүй, тухайн шийдвэр хүчингүй болсон, тухайн асуудлаар шинээр шийдвэр батлагдсан, хуульд нэмэлт, өөрчлөлт орж, тухайн шийдвэр дэх харилцаа цаашид үргэлжлэх боломжгүй болсон зэрэг 11 зүйл, заалтад үнэлгээ өгөөгүй.
4. Салбарт баримтлах бодлогын баримт бичгийг баталсан тогтоолын биелэлт гаргахад бэрхшээлтэй байна. Тухайлбал “Төрөөс газрын тосны салбарт 2017 он хүртэл баримтлах бодлого” баталсан УИХ-ын 2011 оны 65 дугаар тогтоол, “Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлог”-ыг баталсан УИХ-ын 2015 оны 62 дугаар тогтоол, “Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөр” баталсан ЗГ-ын 2017 оны 98 дугаар тогтоол, “Хөгжлийн зам” хөтөлбөрийг баталсан ЗГ-ын 2017 оны 142 дугаар тогтоол, “Гурван тулгуурт хөгжлийн бодлого”-ыг баталсан ЗГ-ын 2018 оны 36 дугаар тогтоолын заалтууд нь урт болон дунд хугацаанд хэрэгжих томоохон зорилтуудыг агуулж байх бөгөөд батлагдсан бодлого, хөтөлбөрийн хэрэгжилтийг тайлагнах үйл ажиллагаа нь Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль болон журмаар зохицуулагдаж байгааг анхаарч хяналтаас хасах нь зүйтэй байна.
5. Зэсийн баяжмал боловсруулах, нүүрснээс шингэн түлш үйлдвэрлэх, нүүрснээс нийлэг байгалийн хий үйлдвэрлэх төслүүдийн хэрэгжилт хангалтгүй, удаашралтай, бодит үр дүн гараагүй байна.
6. Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн баталсан УИХ-ын 2016 оны 12 дугаар тогтоолоор Аж үйлдвэрийн яам /хуучнаар/-ны эрхлэх зарим асуудал нь ХХААХҮЯ, ГХЯ, Шадар сайдын эрхлэх асуудалд хамаарч байх ба УУХҮЯ-ны хяналтаас хасуулах шаардлагатай байна.
7. Газрын тосны бүтээгдэхүүний нөөц бүрдүүлэх, үнэ, хангамжийн асуудлаар батлагдсан, нэг удаагийн зохицуулалттай шийдвэрүүд хяналтаас хасагдахгүй байгааг анхаарах нь зүйтэй.

### **Тав. Зөвлөмж.**

1. Удаашралтай ажлуудыг эрчимжүүлэх, он удаан жил хэрэгжилт хангагдахгүй байгаа шийдвэр, заалтыг хүчингүй болгох, дараагийн шийдвэрийг гаргуулах талаар тодорхой арга хэмжээ авч ажиллах;
2. Төрийн захиргааны удирдлагын газар хяналтанд авагдаж буй шийдвэрийг тухай бүрт нь хариуцах нэгж, албан хаагчийг эзэнжүүлэхэд анхаарах;
3. Төрийн өмчит компаниас холбогдолтой шийдвэрийн хэрэгжилтийг гаргуулж авахад анхаарах;

4. Холбогдох нэгжүүд ЗГХЭГ-т хүргүүлэх тайлангийн боловсруулалт, чанарт анхаарах, мэргэжилтний боловсруулсан тайлан, мэдээллийг харьяалах нэгжийн дарга нар хянаж ирүүлэх;
5. Дотоод нэгжүүд биелэлтийг тогтоосон хугацаанд гаргах, шинэчилж ирүүлж байх;
6. Холбогдох нэгжүүд дүгнэгдээгүй, удааширсан шийдвэрийн хэрэгжилтийг эрчимжүүлж ажиллахад анхаарах.

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтэд хийсэн үнэлгээний тайлан, нэгтгэлийг хавсаргав.

Хянасан:

Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод  
аудитын газрын дарга

Г.Ганхүү

Үнэлгээ хийж, танилцуулга боловсруулсан:

Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод  
аудитын газрын ахлах мэргэжилтэн

Б.Баяржаргал

Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод  
аудитын газрын мэргэжилтэн

Д.Батнайрамдал

Д.Болортуяа

Н.Цогтбаяр

Х.Цэнд-Аюуш

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР